



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/54

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Ховд, Дарви, Дөргөн, Зэрэг, Чандмань сумдад халуун усны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын өмчийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Батзол - Төрийн бус байгууллагын төлөөлөл

П.Эрдэнэ-очир - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Г.Нэмэхбаяр -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Н.Эрдэнэцэцэг /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Г.Нэмэхбаяр /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

